

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

2017 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	I улирал			II улирал			III улирал			IV улирал			Биелэлт	
		1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар		
		I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV		I
<b>Нэг. Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа</b>															
1	Чингэлтэй, Баянгол, Сүхбаатар дүүргүүдийн хүүхдийн түргэн тусламжийн үйл ажиллагааг нэгтгэх														Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны А /01 тоот тушаал болон тус төвийн захирлын ажиллагааг 2017 оны А/02 тоот тушаалаар Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүргүүдийн хүүхдийн түргэн тусламжийн 18 их эмч, 7 жолоочийг 2017 оны 01 сарын 11 өдрөөс эхлэн 103 шугамаар хүлээн авч, үйл ажиллагааг нэгтгэсэн.
2	Хүүхдийн дуудлагын хуудсыг цахим хэлбэрт шилжүүлэн 103 шугамаар хүлээн авах														Хүүхдийн дуудлагыг цахим хэлбэрт шилжүүлэн олон улсын өвчлөлийн 10-р ангиллаар бүртгэхээр саналаа Хууль Зүй Дотоод Хэргийн Яамад зөвшилцөхөөр хүргүүлсэн.
3	Чингэлтэй салбарын барилгыг барих ажиллагааг дэмжлэг үзүүлэх														Чингэлтэй салбар Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороонд баригдахаар газрын асуудал болон барилгын зургыг батлуулсан. Барилга барих мөнгийг 2018 оны төсөвт НИТХ суулгасан.
4	Нийслэлийн засаг даргын 02 албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах.														Захирлын 2017 оны 02 сарын 15-ний өдрийн А/06 тушаал гаргаж 13 заалт бүхий төлөвлөгөө гарган ажилчидад танилцуулан хяналт тавьж ажилласан. Нийт ажил тасалсан, эмнэлэг үйлчилгээний зөрчил гаргасан 9 ажилтанд сахилгын арга хэмжээ, хоёр ажилтанг ажлаас халах арга хэмжээ авсан.
5	Автомашин нөхөн хангалтын талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх														Автомашин нөхөн хангалт, түргэн тусламжийн зориулалтын автомашины судалгааг гарган зохих шатны байгууллагад хүргүүлсэн.
6	Статистик мэдээ мэдээллийн үзүүлэлтийг боловсронгуй болгох														Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 тоот тушаалын СТ-23Б хүүхдийн дуудлагын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулахаар Эрүүл Мэндийн хөгжлийн төвд саналаа оруулсан.
7	Автомашин парк ашиглалтын коэффициентийг нэмэгдүүлэх														Парк ашиглалтын коэффициент өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг хувиар нэмэгдсэн нь дуудлагын ачаалал, хүлээгдлийг багасгах зорилгоор автомашины өдөрт гарах тоог нэмэгдүүлсэнтэй холбоотой.



11	Чанарын өдөрлөг, туршлага солилцох аян, хэлэлцүүлэг зохион байгуулах																																				Чанарын өдөрлөг- 8 удаа " Туршлага солилцох-6 удаа .чанарын аян 7- удаа, эх барихын тулгамдсан асуудлууд хэлэлцүүлэг-2 удаа, үнэлгээ -12 удаа, Чанарын сургалт -55 тус тус зохион байгуулсан Эмчилгээ оношилгооны стандарт хэрэгжилт 86 хувьд хүрсэн НЭМГ-аас зохион байгуулсан "Чанарын сайн туршлага шалгаруулах уралдаанд Нийслэлийн шилдэг сайн туршлагын 20-д шалгарч тусламж үйлчилгээний технологийн чиглэлд: НЭМГ- ын"Өргөмжлөл" -өөр "Автобаазын явуулын засварын багын үйлчилгээ" шагнуулсан. Дамба салбарын түргэн тусламжийн үйлчилгээ -Автобаазын жолооч нарын угаалгын цехийн үйл ажиллагаа -Яаралтай тусламжийн цүнхний цомог тус тус түрүүлж НЭМГ-ийн "Чанарын Батламж" авсан. Мөн "Чанар сайжруулах аяны хүрээнд зохион байгуулсан онол практикийн хуралд "Түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах" илтгэл тэргүүн байр эзэлсэн.
12	Түргэн тусламжийн эрсдлийн үнэлгээг шинэчлэн гарган мөрдөх																																		Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэл, эмзэг байдлын судалгааг гаргасан.Нийт 8 төрлийн эрсдэл тооцож үүнээс 29 эрсдлийг тодорхойлж 20 асуудлыг шийдвэрлэн өнгөрсөн оны мөн үеэс 10 тохиолдлоор буурсан. НМХГ-ын төлөвлөгөөт шалгалтаар Бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Чанар сайжруулах чиглэлээр нийт 14 асуудал дэвшүүлж 100% шийдвэрлэсэн. Үүнээс дээд шатны байгууллагад хандаж -4 асуудал шийдвэрлүүлсэн.		
13	Яаралтай дуудлагын 20 минутын очилтыг нэмэгдүүлнэ.																																	Яаралтай дуудлагын 20 минутын очилт 83.3% буюу өмнөх оноос 1.0%-иар нэмэгдсэн нь түргэн тусламжийн хүлээгдэл буурч хүртээмж нэмэгдсэн.			
14	Байгууллагын цахим хуудас мэдээллээр шинэчлэн баяжуулж тогтмолжуулах																																		Байгууллагын цахим хуудсанд иргэд олон нийтэд нийгмийн эрүүл мэндийн шинэ мэдээ мэдээлэл, зөвлөгөө зөвлөмж, , байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөн дуудлагын статистик мэдээлэл тогтмол шинэчлэн оруулснаар олон нийтэд чиглэсэн байгууллагын цахим ил тод байдлын үйл ажиллагаа сайжирч, иргэд үнэн бодит мэдээ мэдээллээр хангагдаж байна.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ 59, нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл 42, зөвлөгөө зөвлөмж 31, бусад мэдээлэл 28 тавьсан. 2017 оны 11 сарын 30 -ний байдлаар цахим хуудасны хандалт 126882 хүрсэн.		



20	Ажилтан, ажиллагсдын сургалтын хөтөлбөр боловсруулан, тасралтгүй сургах																																																					<p>2017 онд нийт 354 ажилчдад 106 удаагийн 343,5 цагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан. Үүнээс эмч,сувилагч нарт 85 удаагийн нийт 300 цагийн сургалт зохион байгуулснаас 194 эмч, сувилагч хамрагдсан. Жолооч нарт 20 удаагийн 42,5 цагийн сургалт явуулсан 120 жолооч хамрагдсан. Эмч,сувилагч, жолооч нарыг тус сургалтад хамруулснаар газар дээрх болон эмнэлэг хүртэлх тусламж үзүүлэх мэдлэг чадвар дээшилж, улмаар эмнэлэг үйлчилгээ, харьцаа хандлагатай холбоотой алдаа зөрчил гарахаас сэргийлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, олон улсын түвшинд үзүүлж байна. Захиргааны нийт 40 ажилчдад 1 цагийн албан хэрэг хөтлөлтийн сургалт зохион байгуулснаар албан хэрэг стандартын дагуу хөтлөлж байна.</p>
21	Гадаад дотоодын ижил төст байгууллагуудтай хамтран ажиллах																																																					<ul style="list-style-type: none"> <li>- ХБНГУ-ын ЭССЭН хот, УБ хотын хамтын ажиллагааны дагуу 04 дүгээр сард нэгдсэн ариутгалын хэсэг дээр хамтран ажилласан. 06-р сарын 28-ний өдөр төслийн хүрээнд “Эмнэлгийн халдварын хяналт, сэргийлэлт, эрүүл ахуй” сэдэвт семинарт оролцсон.</li> <li>- АМДА олон улсын байгууллагын Азийн эмч нарын холбооны эмч Такуши Сатотой байгууллагын нийт 121 гамшгийн штабын эмч мэргэжилтнүүд бүртгүүлж Такуши Сатогийн “Гамшгийн үеийн тусламж” болон “Анхны тусламжийн аргачлал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</li> <li>- 10 дугаар сарын 16-20 өдрүүдэд Франц улсын, Иргэний аюулгүй байдлын ерөнхий газар, Францын гамшгийн үеийн яаралтай тусламжийн нийгэмлэг болон Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан “Эмнэлгийн яаралтай тусламжийн сургалт”-д тус төвийн 5 их эмчийг хамруулсан.</li> <li>- 10 дугаар сарын 31-ний өдөр БНЧУ-аас Монголд суугаа элчин сайд Иржи Бродски, Чех-Монголын худалдааны танхимын ерөнхийлөгч Лубомир Свобода нар тус төвийн үйл ажиллагаатай танилцан цаашдын хамтын ажиллагааны талаар уулзалт зохион байгуулав. -</li> </ul>

22	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах																																											<p>Нийт 397 ажилтныг Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу 259.699.800 төгрөгөөр урамшуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гурван ажилтанд 2.345.000 төгрөгийн сургалтын зардал,</li> <li>- Дотоодын сургалтад 4.247.000 төгрөг, 7 хоног бүр зохион байгуулдаг ажлын байрны сургалтад 384 ажилтанд 878.900 төгрөг зарцуулсан.</li> <li>- Нийт 147 ажилтанд зэргийн нэмэгдэл 114.858.676 төгрөг,</li> <li>- Хоол унааны мөнгө 397 ажилтанд 291.771.000 төгрөг,</li> <li>- Хөдөлмөрийн хэрэгсэл 7189 ширхэг 30.115.800 төгрөг</li> <li>- 366 ажилтанд 46:098:200 төгрөгийн өвөл, зуны хувцас олгосон.</li> <li>- Ажилчдын хүүхдийн баяраар 434 хүүхдэд 6.510.000 төгрөгийн бэлэг өгч өдөрлөг зохион байгуулсан.</li> <li>- Тус төвийн 204 өндөр настанд сар шинийн баяр болон ахмадын баяраар 14.220.000 төгрөг зарцуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.</li> <li>- 18 ажилтны эхнэр амаржиж 6.895.400 төгрөгийн цалинтай чөлөө олгосон.</li> </ul> <p>Засгийн газрын тогтоолоор 379 ажилтанд 300.000 буюу 119.100.000 төгрөг 34 ажилтанд 17.267.000 төгрөгийн тэтгэмж тусламж, 11 ажилтанд сувилалд амарсны хөнгөлөлт 1.841.780 төгрөг, Орон нутагт ирж очсны зардал 2 өндөр настанд 128.000 төгрөг, тэтгэвэрт гарсан 5 ажилтанд 77.859.491 тэтгэмж тус тус олгуулсан.</p>
23	Эмч, ажилчдыг орон сууцны зээлэнд хамруулахад дэмжлэг үзүүлэх																																											<p>Нийт 10 ажилтан үүнээс захиргааны ажилтан -2, их эмч- 5 жолооч -1 бусад ажилтан -1, банкны хөнгөлөлттэй 8 хувийн зээлд хамрагдаж байранд орсон.</p>

24	Ажилтан ажиллагсдын ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах олон талт ажил зохион байгуулах		<p>Ёс зүйн хэсгийн хороо нь 9 заалт бүхий төлөвлөгөө гаргасан. Нийт 5 салбарт талархлын самбар хийж иргэдээс 124 талархлыг байршуулан эмч, ажилчдыг алдаршуулсан. Ажил дүгнэх үзүүлэлтэд оруулсан.</p> <p>Эмч, эмнэлгийн ажилтны харьцаа хандлага, ёс зүйг сайжруулах чиглэлээр 160 их эмч 36 сувилагч дунд мэргэжилтэн 120 жолооч, захиргааны 42 ажилтанд харьцаа хандлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сэдвээр 9 удаагийн 16 цагийн сургалт зохион байгуулсан.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнгийн багш Баасанбат “ эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба сэтгэл шингэсэн үйлчилгээ” сэдэвтэй 1 цагийн сургалт</li> <li>2. УКТЭмнэлгийн эмч Хэрлэн “Эмчийн ёс зүй харьцаа хандлага” 1 цагийн сургалт зохион байгуулсан.</li> <li>3. АШУҮИСбагш М.Цэрэнбат Эмнэлийн эрх зүй, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй 28 цагийн сургалт</li> <li>4. Сэтгэл засалч эмч Д.Эрдэнэбаатар Эмнэлгийн ажилтны харилцаа, харилцагчдаа нөлөөлөх нь 1 цагийн сургалт</li> <li>5 Н.Оюунмаа– Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах нь 3 цагийн сургалт</li> <li>6. Б.Одгэрэл –НЭМГ мэргэжилтэй Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн харилцаа,</li> <li>7. Сэтгэл засалч эмч Д.Эрдэнэбаатар Утсаар харилцах, стресс менежерт1 цагийн сургалт зохион байгуулсан.</li> </ol> <p>- Нийт ажилчдын харьцаа хандлага ёс зүйг сайжруулах 1 сарын аян зохион байгуулсан.</p> <p>-2017 оны ёс зүй харьцаа хандлагын гомдол өмнөх оныхоос 82 хувиар буурсан.</p>
----	--	--	---

25	Эмч, ажилчдын чийрэгжүүлэлт, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө /дугуй, явган аялал, хийн иог болон ажлын байрны дасгал, цасны баяр/ гарган ажиллана.																																																															Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гаргаж батлуулан ажилласан. 2017 оны 2 дугаар сарын 4-нд цасны баярт мөсөн хотхон хийж байгууллагын хэмжээнд 4-н төрлийн тэмцээн зохион байгуулж эко хоолны өдөрлөг зохиож нийт 200 гаруй ажилчид оролцсон. - 3 дугаар сарын 29- нөөс 4-р сарын 2 нд байгууллагын цомын аварга шалгаруулах 4-н төрөлт тэмцээн зохион байгуулж, МЭМАҮЭХ ноос зохион байгуулсан тэмцээнд оролцож хүрэл медаль авсан - Дөрвөн ажилтан дугуйгаар хичээлсэн. - Гурван салбар автобаазад чийрэгжүүлэлтийн өрөөг шинэчлэн хийн дасгал, ажлын байрны дасгалаар нийт 280 ажилтан албан хаагч хичээллэсэн. Ажлын байранд дасгал хийх нөхцөл боломжоор хангаж, хийж хэвшүүлж ,ажлын өдрүүдэд өдөр бүр 11- 12 цагийн хооронд ажлын байрны дасгалыг зааж хийлгэж, “Golden gym” фитнес клубтэй гэрээ хийж 98 эмч, ажилтанг фитнес, спенинг, аэробек, иогийн төрлүүдэд хамруулж байна. 2 сарын хугацаанд 98 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдаж хамт олноороо 500 кг жин хассан байна. - Дэлхийн алхалтын өдрийг тэмдэглэж хамт олноороо өндөр ширээт рүү /талдаа 7 км/ "Алтан намар" явган аялал хийж олс таталт, mini хөл бөмбөг, АХА 3 төрлийн тэмцээн зохион байгууллаа. ТТӨ халдварт болон ХБӨвчнөөс урьдчилан сэргийлж ДЕНК ФАРМ-тай хамтарч 350 эмч эмнэлгийн ажилчдыг Иммуно актив Д3 витаминь 20 хоногийн хэрэглээгээр витаминжууллаа.
26	Газар хөдлөлтийн үеийн төлөвлөгөөг шинэчлэн сургалтууд зохион байгуулах																																																															Газар хөдлөлтийн үеийн оператив төлөвлөгөө болон шаардагдах зардлыг шинэчлэн Нийслэлийн хэмжээний 5 байгууллагын 352 ажилтанд 66 цагийн сургалт зохион байгуулсан. Гамшигт тэсвэртэй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд 4 сургагч багш бэлдсэн.
27	Гамшгийн үеийн төлөвлөгөөг шинэчлэн мөрдлөг болгох																																																															Монгол Улсын гамшгаас хамгаалах хуулийн дагуу төлөвлөгөөнд тодотгол хийж гэрээнүүдийг шинэчилсэн.
<b>Хоёр. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>																																																																
28	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд нэгдсэн төлөвлөгөө гаргах																																																															Иргэдийн эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сурталчилгаа зохион байгуулах 25 заалт бүхий төлөвлөгөө гаргасан. Нийт 14 телевизээр 80 удаа осол гэмтэл, хоолны хордого, амилуулах суурь тусламжаар сургалт зохион байгуулсан. 2017 оны 11-р сард Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран 1 кредитын сургалт зохион байгуулсан.Нийт 20 эмч .чанарын баг, удирдлагын зөвлөлийн гишүүд оролцсон.





33	Чанарын багийн сайн туршлагын мэдээллийн санг өргөжүүлж нэвтрүүлэх		<p>өргөжүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинээр 8 нэр төрлийн туршлага нэвтрүүлж 9761.0₮ зарцуулсан .</p> <p>НЭМГ-ын даргын 2017 оны 09 дүгээр сарын 1-ны өдрийн А/118 тоот тушаалын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор НЭМГ-аас зохион байгуулсан “Чанарын Сайн туршлага шалгаруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад бидний оролцоо чанарын уралдаанд 2017 оны Нийслэлийн Шилдэг сайн туршлагын 20-д д шалгарч Нийслэлийн сайн туршилагын санд бүртгүүлэв. Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний технологийн чиглэлд: НЭМГ- ын “Өргөмжлөл” өөр</p> <p>“Автобаазын явуулын засварын багын үйлчилгээ” НЭМГ- ын “Чанарын Батламж”аар</p> <p>Дамба салбарын түргэн тусламжийн үйлчилгээ</p> <p>- Автобаазын жолооч нарын угаалагын цехийн үйл ажиллагаа</p> <p>Яаралтай тусламжийн цүнхний цомог тус тус түрүүлж чанарын шагнал хүртсэн.</p>
34	Чанарын сургалтыг үе шаттай зохион байгуулах	0	<p>Чанарын сургалтыг 55 удаа зохион байгуулж нийт эмч эмнэлгийн мэргэжилтэний 89 % хамрагдсан. Эмчилгээ оношлогооны стандарт хэрэгжилт 85 % д. хүрч яаралтай тусламжийн чанар хүртээмж дээшилсэн .</p>
35	Хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн сургалтыг үе шаттай зохион явуулах		<p>Хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн сургалтыг төв салбарын 3 ээлжийн 42 их эмч 5 сувилагч .2-р сард шинээр орсон 10 эмчид нийт 15 цагийн сургалт орсон. ДЭМБ. ЭМЯ.БЗД-ийн ЭМТ-тэй хамтран зохион байгуулсан 5-р сард олон нийтэд тулгуурласан ХӨЦМ-ийн 10 хоногийн сургалтанд 2 их эмч . 2 сувилагчийг бэлдэж сургасан.</p>
36	Иргэдийн эрх зүйн шинэтгэлийн жилтэй холбогдуулан ажилчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах		<p>Хуулийн зөвлөх Д.Цэндсүрэн дотоод журам, хөдөлмөрийн хуулиар 1 цагийн сургалтанд 118 эмч, 24 сувилагч, 32 захирагааны ажилтанг хамруулсан. Эрх зүйн боловсрол ба эрүүл мэнд ТББ- ын захирал АУ-ны доктор, хуульч М.Цэрэнбат Эмнэлгийн эрх зүйгээр 28 цагийн, 2 багц цагийн сургалтад нийт 125 эмч, 32 сувилагчийг хамруулсан.</p> <p>Хуулийн зөвлөх Д. Цэндсүрэн зөрчлийн тухай хуулиар 1 цаг , ЭМГ-ийн Б.Одгэрэл Эрүүл мэндийн тухай хууль, хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах сэдвээр 1 цагийн сургалтад нийт 122 эмч, 32 сувилагч, захиргааны 10 ажилтан хамруулсан.</p>

37	Ажилтан ажиллагсад болон үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлэлт дүгнэлт өгөх																																															2017 онд эмч, эмнэлгийн ажиллагсдын судалгаанд 330 буюу нийт ажиллагсдын 81.4% хамрагдлаа. Судалгаанд хамрагсдын 96.0% нь ерөнхий сэтгэл ханамжид эерэг хариулт өгсөн. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд 325 үйлчлүүлэгч хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын 90.0% нь ерөнхий сэтгэл ханамжид эерэг хариулт өгсөн.
38	Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх олон талт ажил зохион байгуулах																																															Нэгдсэн ариутгалын хэсгийн үйл ажиллагааны журам, хуваарь, нэгдсэн ариутгалын төлөвлөгөө гарган ариутгалын хэсгийн үйл ажиллагааг төвлөрүүлэн нэгтгэн ажиллаж байна. Мөн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын төв лаборатортой гэрээ байгуулан улирал бүр салбаруудын дотоод орчны /агаар, ус, арчдас, ариун материал/ шинжилгээнд хамруулан ажиллаж байна. Үр дүнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гаргаагүй ажилласан. Дуудлагын 50 автомашинд асгарч цацагдсан цус органик бодис цэвэрлэх цомог хийсэн.
39	Төсвийн хөрөнгийн зарцуулалтыг ил тодоор “Шилэн данс”, байгууллагын вэб сайтад байршуулах, мэдээлэх																																															Байгууллагын санхүү, НББ-ийн үйл ажиллагааг цахим хуудаст, вэб сайтад, ил тод байдлын самбарт байршуулав.Үүнд: а/ Шилэн дансанд байршуулбал зохих тайлан, мэдээ, файлуудыг болох 27 мэдээллийг бүтэн жилээр 11 удаа, хагас жилээр 4, улирлаар 4, сараар 36, тухай бүрээр 96 нийт 151 удаа мэдээлсэн б/ Байгууллагын сайтад: - Батлагдсан төсөв, тодотгол төсөв – 2 - 2016 оны бүтэн жилийн, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн баланс, тайлан – 2 - 2018-2020 оны ойрын 3 жилийн төсвийн төлөвлөлтийн санал /хөрөнгө оруулалт, урсгал зардал/ – 1 - Хөрөнгө оруулалтын тайлан – 1 - НЭМГ-ын харъяа байгууллагуудын Аудитын нэгдсэн дүгнэлт – 1 - Нийслэлийн аудитын газрын өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан – 1 - Бусад мэдээлэл зэргийг хугацаанд нь оруулсан. в/ Санхүүгийн ил тодын самбарт: - Батлагдсан төсөв, тодотгол төсөв – 2 удаа - Төсвийн сар бүрийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан – 12 удаа - 2016 оны бүтэн жилийн, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн баланс, тайлан – 2 удаа - 2018-2020 оны ойрын 3 жилийн төсвийн төлөвлөлтийн санал /хөрөнгө оруулалт, урсгал зардал/ – 1 удаа - НЭМГ-ын харъяа байгууллагуудын Аудитын нэгдсэн дүгнэлт – 1 удаа хийсэн.

40	Батлагдсан төсвийн хөрөнгийг хуваарилан зарцуулж, тайлагнах		Төсвийн зарчмыг баримтлан төсвийн төвлөрүүлэн захирагчид /НЭМГ-т/ а/ Санхүүгийн тайлан, балансыг хагас, бүтэн жилээр 2 удаа б/ Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн хуваарилагдсан төсвийн өссөн дүнгээр 12 удаа в/ Төсвийн өр, төлбөр, авлагын мэдээг эдийн засгийн ангилал кодоор болон насжилтаар сар бүр 12 удаа гарган тайлагнаж байна. г/ Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд учирсан хүндрэлийг даван туулахад төсөвт зохицуулалт хийлгэхээр хүсэлт гаргаж 11,12 сард эмийн болон барилгын ашиглалтыг сайжруулах урсгал засварын нийт 26.5 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулахаар зохицуулалт хийлгэв.
41	Байгууллагын санхүү, бүртгэл, НББ-ийг УСНББ-ийн стандартыг баримтлан хэрэгжүүлэх		а/ Эмийн агуулахын бүртгэлд 1, төвийн эмийн санд 1, 3 салбарт 3, нягтлан бодогчийн хяналтанд 1 нийт 6 эмийн сангийн программыг 1,980.0 мянган төгрөгөөр суулгуулсан. Уг эмийн сангийн программын сургалтын хөтөлбөрт эмийн санч нараа бүрэн хамруулав. б/ Санхүүгийн тайлан баланс бэлтгэхэд НББ-ийн дансдын кодын өөрчлөлтөөр 2017 оны эхний хагас жилд санхүүгийн тооцооллын программын өөрчлөлтийг шинэчлүүлэн Улсын секторын НББ-ийн стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.
42	Худалдан авалтын сонгон шалгаруулалтыг хэмнэлттэй үр ашигтай зохион явуулах		Гэрээт харуулын үйлчилгээ үзүүлэх нээлттэй тендерийг 2017.02.17 нд зарлаж 04.17 ноос эхлэн 70.1 сая төгрөгөөр гэрээг байгуулан жилд 1739.1 мянган төгрөгний арвилан хэмнэлт гаргасан.
43	Нийслэлийн засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот хөтөлбөр"-ийн хүрээнд 12 зүйлтэй төлөвлөгөө гарган ажиллаа.		"Аз жаргалтай хот" хөтөлбөрийн хүрээнд 5 чиглэл бүхий 12 зүйлтэй төлөвлөгөө гарган ажилласнаас иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх зорилгоор Чингэлтэй салбар барих барилгын зураг, газрын асуудал шийдэгдсэн боловч барилга баригдах төсөв нь 2018 оны нэмэлт тодотголд тусгагдсан. Төлөвлөгөө 91.6 хувийн биелэлттэй байна.

ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

Ц.ПҮРЭВДАШ

НЭГТГЭСЭН:

ДЭД ЗАХИРАЛ

С.АРИУНБОЛД